

Аюулгүй ажиллагааны зөвлөмжийн тухай

ОХУ-ын ТВС-2МС маягийн RA-2099G бүртгэлийн дугаартай агаарын хөлгийн 2017.06.02-ны өдрийн ослын шинжлэн шалгах ажиллагааг ТУХН-ийн орнуудын агаарын хөлгийн ослыг шинжлэн шалгах байгууллага МАК гүйцэтгэн тайланг ирүүлсэн. Шинжлэн шалгах ажиллагааны үеээр дараах зөрчил дутагдлууд илэрчээ (38 дугаар хуудас). Үүнд:

- 2017.06.02-нд Чингис хаан нисэх буудлаас хөөрөхийн өмнөх агаарын хөлгийн жин, төвлөрөлт нь нислэгийн ашиглалтын РЛЭ зааварт тогтоосон ашиглалтын хязгаараас хэтэрсэн,
- Агаарын хөлгийн хөөрөлтийн үзүүлэлтийг тооцоолох нислэгийн өмнөх бэлтгэл хангалтгүй хийгдсэн. ТВС-2МС маягийн RA-2099G бүртгэлийн дугаартай агаарын хөлгийн РЛЭ зааварт төвлөрөлтийн график байхгүй байна,
- Зорчигчийн тоо хэтрүүлсэн болон №15 дугаар шпангоутын ард нэмэлт ачаа байрлуулсан нь РЛЭ зааврын шаардлагатай нийцэхгүй байна,
- Агаарын хөлгийн дарга тухайн маягийн агаарын хөлгөөр дадлага туршлага багатай байсан нь уулархаг бүсийн аэродромоос хамгийн их хөөрөлтийн жинтэй, арын хязгаараас хэтэрсэн төвлөрөлттэй байдалтай нислэг үйлдэх үед ослын нөхцөл үүсэж эхлэх үеийг цаг тухайд нь тодорхойлох, урьдчилан сэргийлэх арга хэмжээг авахад нөлөөлсөн байх магадлалтай зэрэг болно.

Мөн ТВС-2МС агаарын хөлгийн аэродинамикийн үзүүлэлт бүрэн хэмжээгээр байхгүй байгаагаас агаарын хөлгийн Улаанбаатараас хөөрөлт үйлдэх үеийн байдлыг харьцуулан үнэлэх боломжгүй байгаа талаар дурьджээ (35 дугаар хуудас).

МАК дараах аюулгүй ажиллагааны зөвлөмжүүдийг RA-2099G бүртгэлийн дугаартай агаарын хөлгийн ослыг шинжлэн шалгасан тайлангийн 5 дугаар бүлэг, 39 дүгээр хуудсанд тусгажээ. Үүнд:

ОХУ-ын нисэхийн эрх баригч нарт

- Ан-2, ТВС-2МС маягийн агаарын хөлгийг ашиглагч нисэхийн ажилтнуудад ТВС-2МС маягийн RA-2099G бүртгэлийн дугаартай агаарын хөлгийн ослын шинжлэн шалгах ажиллагааны үр дүнгийн талаар мэдээлэх,
- Илэрсэн аюулын хүчин зүйлсийг харгалзан оршиж байгаа эрсдэлүүдийг үнэлж, ТВС-2МС маягийн агаарын хөлгийг цаашид аюулгүй ашиглахтай холбоотой зохих шийдвэрийг гаргах,
- Нислэгийн туршилтийн үр дүн болон ашиглалтын төвлөрөлтийн хязгаарыг тогтоосон үндэслэлийг дахин шалгах

Агаарын тээврийн компаний удирдлага болон хувийн эзэмшигч нарт

- Үндсэн баазаас өөр байрлалд нислэг үйлдэж буй нисэх багийн ажлыг үечлэлтэйгээр шалган заавал мөрдөх баримт бичигт тогтоогдсон шаардлагыг биелүүлж байгаа эсэхийг хянах,
- Ан-2, ТВС-2МС маягийн агаарын хөлгийн нисэх бүрэлдэхүүнд РЛЭ зааврын дараах бүлгүүдээр нэмэлт сургалт хийх:
 - Ашиглалтын ерөнхий хязгаарлалтын талаарх «Общие эксплуатационные ограничения» бүлэг («Максимальное количество людей на борту», «Максимальная взлетная и посадочная масса самолета», «Диапазон центровок самолета», «Эксплуатационные ограничения самолета» дэд бүлгүүд);
 - Нислэгийн бэлтгэлийн талаарх «Подготовка к полету» бүлэг («Общие указания по расчету полетов» дэд бүлэг);
 - Нислэг үйлдэх талаарх «Выполнение полета» бүлэг («Особенности поведения самолета на больших углах атаки» бүлэг).
- Нислэгийн өмнөх агаарын хөлгийн төвлөрөлтийн тооцоог төвлөрөлтийн график болон хүндийн төвийн харьцангуй моментын аргуудыг ашиглан хийх тухай сургалт, дадлагыг нисэх бүрэлдэхүүнд хийх,
- Тухайн агаарын хөлгийн хөөрөлтийн хамгийн их жин, төвлөрөлтийн тооцоог хийхэд шаардлагатай болон техникийн хяналтын бусад баримт бичгүүд агаарын хөлөгт бүрт бүрэн байгаа эсэх, тэдгээрийг цаг тухайд нь бөглөж байгаа эсэхийг шалгах арга хэмжээг авах зэрэг болно.